ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2026/213/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2026 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъясүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/184
танай ____________-ны № ________________-т

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.ХҮРЭЛБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.5 мянган төгрөг, дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.3 мянган төгрөг, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

**Аудитын гол асуудал**

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай" 01/225 дугаартай зөвшөөрлийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 48,424.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчилж 34,101,0 мянган төгрөгөөр тогтоон бүртгэлд тусгасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

4196020196

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 91.0 хувиар дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **433,127,448.22** | **395,376,256.66** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **325,720,620.06** | **313,763,410.10** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **325,720,620.06** | **313,763,410.10** |
| **3121** | **Төгрөг** | **325,720,620.06** | **313,763,410.10** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 325,720,620.06 | 313,763,410.10 |
| **33** | **АВЛАГА** | **22,168,200.00** | **230,798.40** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 110,900.00 | 230,798.40 |
| **335** | **Бусад авлага** | **22,057,300.00** | **-** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 22,011,200.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 46,100.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **85,238,628.16** | **81,382,048.16** |
| **351** | **Түүхий эд материал** | **65,807,392.26** | **66,025,892.26** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 65,165,792.26 | 65,384,292.26 |
| 35130 | Эм боох материал | 641,600.00 | 641,600.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **19,431,235.90** | **15,356,155.90** |
| 35450 | Барилгын засварын материал | 4,594,180.00 | 144,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 14,837,055.90 | 14,837,055.90 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,560,942,926.75** | **3,481,105,164.52** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,560,942,926.75** | **3,481,105,164.52** |
| **392** | **Биет хөрөнгө** | **3,476,253,297.20** | **3,399,406,997.89** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,454,906,846.82 | 3,454,906,846.82 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (361,235,377.32) | (418,795,215.36) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 8,200,000.00 | 8,200,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (8,200,000.00) | (8,200,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 321,376,852.00 | 345,276,925.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (141,136,631.70) | (173,759,875.62) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 244,967,440.36 | 234,025,738.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (107,035,890.28) | (88,313,689.05) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 74,546,000.00 | 71,850,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (30,212,666.74) | (32,183,333.42) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 20,076,724.06 | 6,399,601.16 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **84,689,629.55** | **81,698,166.63** |
| 39301 | Програм хангамж | 4,583,942.05 | 4,738,942.05 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (794,312.50) | (3,940,775.42) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 80,900,000.00 | 80,900,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,994,070,374.97** | **3,876,481,421.18** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **15,530,725.51** | **5,183,568.94** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **15,530,725.51** | **5,183,568.94** |
| **413** | **Өглөг** | **15,530,725.51** | **5,183,568.94** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 9,936,374.57 | - |
| **4136** | **Бусад өглөг** | **5,594,350.94** | **5,183,568.94** |

| | | | |
|---|---|---|---|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 657,452.00 | 246,670.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 4,936,898.94 | 4,936,898.94 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,978,539,649.46** | **3,871,297,852.24** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **3,978,539,649.46** | **3,871,297,852.24** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 383,740,312.86 | 383,740,312.86 |
| 51101 | Өмч: - төрийн | 383,740,312.86 | 383,740,312.86 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,973,075,024.01** | **1,865,833,226.79** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,973,075,024.01 | 1,973,075,024.01 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (107,241,797.22) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,621,724,312.59 | 1,621,724,312.59 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,994,070,374.97** | **3,876,481,421.18** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,113,175,849.44** | **2,362,905,379.78** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **66,172,075.44** | **54,823,682.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **66,172,075.44** | **54,823,682.50** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 34,122,173.44 | 39,023,882.50 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 738,220.00 | - |
| 120009 | Бусад орлого | **31,311,682.00** | **-** |
| **122** | **Тусламжийн орлого** | - | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 15,799,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,047,003,774.00** | **2,308,081,697.28** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,734,977,400.00** | **2,014,338,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,734,977,400.00 | 2,014,338,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **312,026,374.00** | **293,742,797.28** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 312,026,374.00 | 293,742,797.28 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,046,153,307.92** | **2,468,228,987.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,046,153,307.92** | **2,468,228,987.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,021,047,627.92** | **2,402,144,687.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,256,109,184.80** | **1,564,297,480.43** |
| 210101 | Үндсэн цалин | 1,029,455,095.50 | 936,396,618.28 |
| 210102 | Нэмэгдэл | 186,607,628.30 | 567,893,370.81 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 37,849,213.87 |
| 210104 | Урамшуулал | 40,046,461.00 | 22,158,277.47 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **151,617,404.92** | **192,737,648.25** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 99,120,069.08 | 130,548,039.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,998,120.69 | 15,621,663.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,196,211.78 | 8,208,929.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,114,017.76 | 7,580,913.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,188,985.61 | 30,778,102.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **289,284,473.91** | **288,742,797.28** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,950,857.91 | 17,409,181.28 |
| 210302 | Түлш, халаалт | 269,803,616.00 | 269,803,616.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,530,000.00 | 1,530,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **16,835,346.00** | **33,980,811.40** |
| 210401 | Бичиг хэрэг | 9,218,260.00 | 8,655,110.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,237,000.00 | 7,205,960.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 380,086.00 | 734,774.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 17,384,967.40 |
| **2105** | **Нормативт зардал** | **88,469,270.00** | **89,779,820.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 925,000.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 81,952,970.00 | 79,461,040.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,591,300.00 | 10,318,780.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **19,263,610.00** | **12,605,080.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 962,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 18,301,610.00 | 12,605,080.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,299,000.00** | **4,210,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,299,000.00 | 4,210,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **41,312,967.00** | **18,444,057.31** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 37,600,000.00 | 600,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,712,967.00 | 17,844,057.31 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **148,856,371.29** | **197,346,992.33** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,115,510.39 | 40,685,015.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 928,000.00 | 88,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 141,812,860.90 | 156,573,977.33 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **25,105,680.00** | **66,084,300.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **25,105,680.00** | **66,084,300.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 25,105,680.00 | 66,084,300.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **67,022,541.52** | **(105,323,607.22)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **3,000,000.00** | **1,918,190.00** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 3,000,000.00 | 1,918,190.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(3,000,000.00)** | **(1,918,190.00)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **64,022,541.52** | **(107,241,797.22)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,079,519,156.00** | **2,308,081,697.28** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **32,515,382.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **32,515,382.00** | - |
| 120009 | Бусад орлого | 32,515,382.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,047,003,774.00** | **2,308,081,697.28** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,734,977,400.00** | **2,014,338,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,734,977,400.00 | 2,014,338,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **312,026,374.00** | **293,742,797.28** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 312,026,374.00 | 293,742,797.28 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,920,999,982.62** | **2,302,752,407.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,920,999,982.62** | **2,302,752,407.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,871,544,482.62** | **2,236,668,107.24** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,238,845,825.81** | **1,574,818,901.32** |
| 210101 | Үндсэн цалин | 764,590,735.77 | 936,396,618.28 |
| 210102 | Нэмэгдэл | 434,208,629.04 | 567,893,370.81 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 48,350,634.76 |
| 210104 | Урамшуулал | 40,046,461.00 | 22,178,277.47 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **146,232,129.51** | **192,283,400.33** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 97,175,831.42 | 130,548,039.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,283,697.57 | 15,621,663.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,202,511.78 | 8,208,929.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,114,017.76 | 7,580,913.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,456,070.98 | 30,323,854.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **309,087,874.00** | **288,742,797.28** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,783,973.91 | 17,409,181.28 |
| 210302 | Түлш, халаалт | 291,103,900.00 | 269,803,616.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.09 | 1,530,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **58,927,850.00** | **81,379,030.00** |
| 210502 | Хоол, хүнс | 58,927,850.00 | 81,379,030.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,938,500.00** | **5,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,938,500.00 | 5,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,425,533.56** | **31,265,928.31** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 792,900.00 | 410,782.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,632,633.56 | 30,855,146.31 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **101,086,769.74** | **63,178,050.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 87,218,169.74 | 51,366,960.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,868,600.00 | 11,811,090.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **49,455,500.00** | **66,084,300.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **49,455,500.00** | **66,084,300.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 49,455,500.00 | 66,084,300.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **158,519,173.38** | **5,329,290.04** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **37,853,942.05** | **17,286,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **37,853,942.05** | **17,286,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **37,853,942.05** | **17,286,500.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 37,853,942.05 | 17,286,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(37,853,942.05)** | **(17,286,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **120,665,231.33** | **(11,957,209.96)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 205,055,388.73 | 325,720,620.06 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 325,720,620.06 | 313,763,410.10 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** **/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 383,740,312.86 | 1,640,287,123.59 | 1,890,489,671.49 | 3,914,517,107.94 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 18,562,811.00 | 18,562,811.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **383,740,312.86** | **1,640,287,123.59** | **1,909,052,482.49** | **3,933,079,918.94** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 64,022,541.52 | 64,022,541.52 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **383,740,312.86** | **1,621,724,312.59** | **1,973,075,024.01** | **3,978,539,649.46** |
| **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **383,740,312.86** | **1,621,724,312.59** | **1,973,075,024.01** | **3,978,539,649.46** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **383,740,312.86** | **1,621,724,312.59** | **1,973,075,024.01** | **3,978,539,649.46** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (107,241,797.22) | (107,241,797.22) |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **383,740,312.86** | **1,621,724,312.59** | **1,865,833,226.79** | **3,871,297,852.24** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,671,285,200.00** | **2,308,081,697.28** | **363,203,502.72** | **86.40** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,045,709,400.00** | **2,014,338,900.00** | **31,370,500.00** | **98.47** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,045,709,400.00 | 2,014,338,900.00 | 31,370,500.00 | 98.47 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **296,680,900.00** | **293,742,797.28** | **2,938,102.72** | **99.01** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 296,680,900.00 | 293,742,797.28 | 2,938,102.72 | 99.01 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **328,894,900.00** | **-** | **328,894,900.00** | **-** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,175,000.00 | - | 3,175,000.00 | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 325,719,900.00 | | 325,719,900.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,671,285,200.00** | **2,320,038,907.24** | **351,246,292.76** | **86.85** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,671,285,200.00** | **2,320,038,907.24** | **351,246,292.76** | **86.85** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,599,009,500.00** | **2,253,954,607.24** | **345,054,892.76** | **86.72** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,850,376,800.00** | **1,574,818,901.32** | **275,557,898.68** | **85.11** |
| 210101 | Үндсэн цалин | 1,133,737,000.00 | 936,131,618.28 | 197,605,381.72 | 82.57 |
| 210102 | Нэмэгдэл | 694,247,700.00 | 567,893,370.81 | 126,354,329.19 | 81.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 48,615,634.76 | (48,615,634.76) | |
| 210104 | Урамшуулал | 22,392,100.00 | 22,178,277.47 | 213,822.53 | 99.05 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **231,297,100.00** | **192,283,400.33** | **39,013,699.67** | **83.13** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 157,282,000.00 | 130,548,039.56 | 26,733,960.44 | 83.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,503,800.00 | 15,621,663.45 | 2,882,136.55 | 84.42 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,251,900.00 | 8,208,929.06 | 1,042,970.94 | 88.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,251,900.00 | 7,580,913.68 | 1,670,986.32 | 81.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 37,007,500.00 | 30,323,854.58 | 6,683,645.42 | 81.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **291,680,900.00** | **288,742,797.28** | **2,938,102.72** | **98.99** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,877,200.00 | 17,409,181.28 | 4,468,018.72 | 79.58 |
| 210302 | Түлш, халаалт | 269,803,700.00 | 269,803,616.00 | 84.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 1,530,000.00 | (1,530,000.00) | |
| **2105** | **Нормативт зардал** | **103,806,900.00** | **81,379,030.00** | **22,427,870.00** | **78.39** |
| 210502 | Хоол, хүнс | 103,806,900.00 | 81,379,030.00 | 22,427,870.00 | 78.39 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,000,000.00** | **5,000,000.00** | **-** | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **36,174,200.00** | **32,391,928.31** | **3,782,271.69** | **89.54** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,585,800.00 | 410,782.00 | 3,175,018.00 | 11.46 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 32,588,400.00 | 31,981,146.31 | 607,253.69 | 98.14 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **80,673,600.00** | **79,338,550.00** | **1,335,050.00** | **98.35** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 68,658,000.00 | 67,305,960.00 | 1,352,040.00 | 98.03 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,015,600.00 | 12,032,590.00 | (16,990.00) | 100.14 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **72,275,700.00** | **66,084,300.00** | **6,191,400.00** | **91.43** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **72,275,700.00** | **66,084,300.00** | **6,191,400.00** | **91.43** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 72,275,700.00 | 66,084,300.00 | 6,191,400.00 | 91.43 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **325,720,620.06** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **313,763,410.10** | | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 350,513.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайланд урсгал засварын 20.0 мянган төгрөгийн зардлыг цалингийн зардалд тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 7, 8, 9 дүгээр сарын үндсэн хөрөнгийн 37,951.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг бүртгээгүй.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг 296,742.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд хандив тусламжаар авсан 15,799.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн 7,315.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 24,682.3 мянган төгрөгөөс бага байгаа тул **“Өөрчлөлтгүй”** дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 7,315.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,926.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2,388.2 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

### 5.2.2 Албан шаардлага

Нийт 7 ажилтны 2024 оны Нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн төрлийг 01001 кодоор тайлагнахыг 22001 кодоор буруу тайлагнаж нийт 4,926.9 мянган төгрөгийн төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "оршин байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн:Нийгмийн даатгалын залруулга тайланг гарган харьяа Нийгмийн даатгалын газраар баталгаажуулж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

### 5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Санхүүгийн тайлантай холбоотой асуудал***

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн

тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

***2. Зардлын данстай холбоотой асуудал***

Илрүүлэлт:

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын дагуу тайлант онд 1-5 дугаар ангийн сурагчдын тоогоор 27,389 сурагчдад өдөр ногдох нормативаар тооцоход 68,472.5 мянган төгрөгийн зарцуулахаас 66,049.8 мянган төгрөгийн зардал гаргаж, 2,388.2 мянган төгрөгийг дутуу зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4-т "Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцоох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын 1-т "ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.500 төгрөгөөр тогтоосугай" гэж заасныг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан нормативын дагуу сурагчдын үдийн болон дотуур байранд байрлагдаг сурагчдын хоолны түүхий эд авах зардлыг олгон давтан гаргахгүй ажиллах.

***3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал***

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 21 ширхэг 18,827.5 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэж  заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** */мянган төгрөгөөр/*

| д/д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Санхүүгийн үр дүнгийн тайланд урсгал засварын 20.0 мянган төгрөгийн зардлыг цалингийн зардалд тайлагнасан. | 1 | 20.0 | | | 1 | 20.0 | 1 | 20.0 | | |
| 2 | Санхүүгийн үр дүнгийн тайланд 7, 8, 9 дүгээр сарын үндсэн хөрөнгийн 37,951.2 мянган төгрөгийн элэгдлийг зардлыг бүртгээгүй. | 1 | 37,951.3 | 1 | 37,951.3 | | | 1 | 37,951.3 | | |
| 3 | Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг 296,742.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. | 1 | 296,742.8 | 1 | 296,742.8 | | | 1 | 296,742.8 | | |
| 4 | Санхүүгийн үр дүнгийн тайланд хандив тусламжаар авсан 15,799.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр бүртгэсэн. | 1 | 15,799.8 | | | 1 | 15,799.8 | 1 | 15,799.8 | | |
| | **Дүн** | **4** | **350,513.9** | **2** | **334,694.1** | **1** | **15,819.8** | **4** | **350,513.9** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| 2 | Нийт 7 ажилтны 2024 оны Нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн төрлийг 01001 кодоор тайлагнахыг 22001 кодоор буруу тайлагнаж нийт 4,926.9 төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй. | 1 | 4,926.9 | | | 1 | 4,926.9 | | | | | | |
| 3 | Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын дагуу тайланд онд суралцсан давхардсан 1-5 дугаар ангийн сурагчдын тоогоор 27,389 сурагчдад өдөр ногдох нормативаар тооцоход 68,472.5 мянган төгрөгийн зарцуулахаас 66,049.8 мянган төгрөгийн зардал гаргаж, 2,388.2 мянган төгрөгийг дутуу зарцуулсан. | 1 | 2,388.2 | | | | | 1 | 2,388.2 | | | | |
| 4 | Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 21 ширхэг 18,827.5 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| | **Дүн** | **4** | **7,315.1** | | | **1** | **4,926.9** | **3** | **2,388.2** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөг/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 139 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 28 мэдээлэл, байршуулаагүй 4 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 1,718,230.3 мянган төгрөгийн 50 гүйлгээ, зарлагын 130,224.0 мянган төгрөгийн 7 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 14,007.9 мянган төгрөгийн 1 гүйлгээ байршуулаагүй. Мөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, байршуулаагүй байна. | 1 | 1,862,462.2 | | | 1 | 1,862,462.2 | | - |
| **Дүн** | **1** | **1,862,462.2** | | | **1** | **1,862,462.2** | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **1,862,462.2** | | | **1** | **1,862,462.2** | | |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр Дугаар 48-20810579-ТӨА-2026/213/НА-СТА-ТШ3 Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 139 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 28 мэдээлэл, байршуулаагүй 4 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 1,718,230.3 мянган төгрөгийн 50 гүйлгээ, зарлагын 130,224.0 мянган төгрөгийн 7 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 14,007.9 мянган төгрөгийн 1 гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.10-т “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Хүрэлбаатар, нягтлан бодогч Б.Дашхуяг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр Дугаар 49-20810579-ТӨА-2026/213/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт 7 ажилтны 2024 оны Нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн төрлийг 01001 кодоор тайлагнахыг 22001 кодоор буруу тайлагнаж нийт 4,926,898.94 /дөрвөн сая есөн зуун хорин зургаан мянга найман зуун ерэн найман/ төгрөг 94 мөнгөний өр төлбөрийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-т “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын залруулга тайланг гарган, өр төлбөрийг үүссэн зөрчлийг зогсоож биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Угтаалцайдам сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Хүрэлбаатар, нягтлан бодогч Б.Дашхуяг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn